ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цог өрнөх ОНӨААТҮГ-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/11/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Даланзадгад хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023·03·15 № 227

танай _____-ны №_____ -т

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЦОГ
ӨРНӨХ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.АРДТҮМЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цогтцэций сумын Цог өрнөх ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Цогтцэций сумын Цог өрнөх ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй Өмнөговь аймгийн Засаг дарга зорилтот түвшингийг баталж байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь хандив тусламжаар ирсэн хөрөнгийг урт хугацаат өр төлбөр дансанд бүртгэж, жил бүрийн элэгдлийн дүнгээр орлого хүлээн зөвшөөрсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

• 016020308

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	481.2	510.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,143.2	5,070.9
Нийт хөрөнгийн дүн	**5,624.4**	**5,581.7**
Нийт өр төлбөрийн дүн	2,770.2	2,697.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,854.2	2,883.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**5,624.4**	**5,581.7**
Орлогын дэлгэрэнгүй тайлан		
Борлуулалтын орлогын дүн	904.8	990.6
Үйл ажиллагааны зардал болон ББӨ-н дүн	845.7	939.9
Татварын өмнөх ашиг	59.0	50.7
Татварын дүн	5.9	5.1
Татварын дараах ашиг	53.1	45.6
Олз/ гарз	-	15.9
Цэвэр ашиг	53.1	29.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмч	4,215.8	4,215.8
Дахин үнэлгээний нэмэгдэл	98.8	(1,513.5)
Хуримтлагдсан ашиг	(1,513.5)	2,801.0
Эцсийн үлдэгдэл	2,801.0	2,883.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	814.9	993.5
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	739.0	941.1
Үйл ажиллагааны ЦМГ	75.9	52.4
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	75.9	52.4
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	259.1	335.0
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	335.0	387.3
Зорилтот түвшин	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт борлуулалтын орлого	938.3	990.6
Үйл ажиллагааны зардал	937.1	939.9
Үйл ажиллагааны бус зардал	-	-
Нийт зардал	937.1	939.9
Татвар төлөхийн өмнөх ашиг	1.2	50.7
Татвар	0.1	5.1
Татварын дараах ашиг	1.1	45.6
Олз/ гарз		-16.0
Цэвэр ашиг	1.1	29.6

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160.7 сая төгрөгийн алдаа илэрснээс 160.7 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

Аудитаар нийт 1 зөрчил[1] илэрснээс, 1 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

3.1 Төлбөрийн акт
Төлбөрийн акт тогтоогүй

3.2 Албан шаардлага
Албан шаардлага өгөгдөөгүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 167 мэдээлэл мэдээлэхээс 166 мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хугацаа болоогүй байгаа тул мэдээлээгүй байна.
Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг мөрдөн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан үндсэн хөрөнгө Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй	1	147,321.7			1	147,321.7	1	147,321.7				
Татварын тайланд НӨАТ, суутгачийн хувь хүнд логосон орлогоос суутгасан татвар, ААНОАТ, Үл хөдлөх хөрөнгийн эд хөрөнгийн албан татвар, рашаан ус ашигласны төлбөр илүү төлөлттэй Санхүү байдлын тайланд авлагаар тайлагнаагүй	1	13,382.7			1	13,382.7	1	13,382.7				

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дүн	**2**	**160,704.4**			**2**	**160,704.4**	**2**	**160,704.4**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгуулла гад шилжүүл сэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Зөрчил иргээгүй												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илрээгүй								
Дүн								
Нийт дүн	1						1	